



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэ ховд ББХК ОНӨОХХК 2025 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/010/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 99031809 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026-03-13 № 244
танай _____-ны № _____-г

“ШИНЭ ХОВД БАРУУН БҮСИЙН
ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ” ОНӨОХХК-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ю.АЗАМАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шинэ ховд баруун бүсийн хөгжлийн корпораци” ОНӨОХХК-ны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.3, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2, 20.2.6, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2, 26 дугаар зүйл, 30 дугаар зүйлийн 3 дахь заалтуудтай тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 2 тракторын түрээсийн гэрээгээр бусдад түрээсэлсэн ч орлогыг дансанд төвлөрүүлээгүй, гэрээг дүгнээгүй, авлагаар бүртгээгүй;
- Тайлант оны нэгтгэсэн санхүүгийн тайланд Ховд агро парк ХХК-ийн тайланг нэгтгээгүй,
- Тайлант онд 93,700.7 мянган төгрөгийг хувь хүн, аж ахуйн нэгжүүдээс бүрдүүлсэн ч и баримт олгоогүй;
- Байгууллагын данс бүртгэлт тусгагдсан 4,799.0 мянган төгрөгийн хөрөнгө биетээр байхгүй, буруутай албан тушаалтнаас аваагүй, авлагаар бүртгээгүй;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1000 тн зоорь болон үйлдвэрүүдийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй, орлого олох нөөц боломжийг бүрэн ашиглаагүй;

8426050586

- Тайлант онд худалдан авсан бараа материалыг бүртгэхдээ НӨАТ-г хасаагүй нийт дүнгээр нь бүртгэсэн.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 18 тоот тогтоолоор “Шинэ хөдөө” төслийн хөрөнгө оруулалтаар олгогдож буй хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн түрээслэх, ашиглах жагсаалт”-ыг баталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Шинэ ховд баруун бүсийн хөгжлийн корпораци” ОНӨОХХК нь 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,216.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 969.6 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/26 тоот захирамжаар байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөлийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталжээ. Тайлант онд ОНӨОХХК болсноор “Шинэ ховд ББХК”, “Үйлдвэр технологийн парк” ХХК-ийн тайланг нэгтгэн гаргасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 сарын 31-ны өдрөөрх

Үзүүлэлт	1. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	2. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1. ХӨРӨНГӨ	265,343,987.39	700,740,379.24
1.1 Эргэлтийн хөрөнгө		0
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,192,368.85	10,563,424.32
1.1.2 Дансны авлага	225,915,999.94	470,328,020.32
1.1.6 Бараа материал	38,235,618.60	219,848,934.60
1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн	265,343,987.39	797,026,285.88
1.2 Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1 Үндсэн хөрөнгө	4,644,419,440.13	6,312,699,500.99
1.2.2 Биет бус хөрөнгө	18,842,334,000.00	18,842,334,000.00
1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	23,486,753,440.13	25,155,033,500.99
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,752,097,427.52	25,855,773,880.23
2.1.1.1 Дансны өглөг	1,276,517,723.60	1,262,351,973.60
2.1.1.3 Татварын өр	7,405,507.78	-
2.1.1.5 Богино хугацаат зээл	19,476,569.64	-
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	16,648,592.00	81,308,083.49
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,320,048,393.02	1,343,660,057.09
2.2 Өр төлбөрийн нийт дүн	1,320,048,393.02	1,343,660,057.09
2.3 Эздийн өмч	-	-
2.3.1 Өмч:	2,000,000.00	2,000,000.00
2.3.1.1 - төрийн	2,000,000.00	2,000,000.00
2.3.6 Эздийн өмчийн бусад хэсэг	22,267,485,330.00	22,267,485,330.00
2.3.7 Хуримтлагдсан ашиг	-554,995.15	2,758,434,723.39
Тайлант үе	163,118,699.65	-515,806,230.25
2.3.9 Эздийн өмчийн дүн	22,432,049,034.50	24,512,113,823.14
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	23,752,097,427.52	25,855,773,880.23
1 Актив	23,752,097,427.52	25,855,773,880.23
2 Пассив	23,752,097,427.52	25,855,773,880.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын тайлан

2025 оны 12 сарын 31-ны өдрөөрх

Үзүүлэлт	1. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	2. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1. Борлуулалтын орлого (цэвэр)	464,072,419.79	487,209,452.73
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	300,953,720.14	447,025,582.76
3. Нийт ашиг (алдагдал)	163,118,699.65	40,183,869.97
10. Ерөнхий ба удирдлагын зардал		555,990,100.22
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	163,118,699.65	-515,806,230.25
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	163,118,699.65	-515,806,230.25
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	163,118,699.65	-515,806,230.25
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	163,118,699.65	-515,806,230.25
25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 сарын 31-ны өдрөөрх

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2. Залруулсан үлдэгдэл	2,000,000.00	22,267,485,330.00	554,995.15	22,268,930,334.85

3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	163,118,699.65	163,118,699.65
8. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	2,000,000.00	22,267,485,330.00	162,563,704.50	22,432,049,034.50
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	2,595,871,018.89	2,595,871,018.89
10. Залруулсан үлдэгдэл	2,000,000.00	22,267,485,330.00	2,758,434,723.39	25,027,920,053.39
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-515,806,230.25
16. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/	2,000,000.00	22,267,485,330.00	2,242,628,493.14	24,512,113,823.14

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 сарын 31-ны өдрөөрх

Үзүүлэлт	1. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	2. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1 Мөнгөн орлогын дүн	464,072,419.79	710,642,637.88
1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	464,072,419.79	710,642,637.88
1.2 Мөнгөн зарлагын дүн	473,406,406.34	701,271,582.41
1.2.1 Ажиллагчдад төлсөн	208,521,889.44	395,684,560.95
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	25,240,773.00	49,460,570.00
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	188,902,742.90	233,889,721.46
1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	2,471,429.00	-
1.2.7 Татварын байгууллагад төлсөн	-	22,236,730.00
1.2.9 Бусад мөнгөн зарлага	48,269,572.00	-
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-9,333,986.55	9,371,055.47
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-9,333,986.55	9,371,055.47
5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,526,355.40	1,192,368.85
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,192,368.85	10,563,424.32
1 БЦМГ /1,3+2,3+3,3+4/	-9,333,986.55	9,371,055.47
2 БЦМГ /6-5/	-9,333,986.55	9,371,055.47
3 Зөрүү	-	0.00

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлд

2025 оны 12 сарын 31-ны өдрөөрх

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он Төлөвлөгөө	2025 он Гүйцэтгэл	Зөрүү +,-
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	мян,төг	1,411,491.0	487,209.5	-924,281.5
2	Нийт зардал	мян,төг	1,411,491.0	1,003,015.7	-408,475.3
3	Үйл ажиллагааны ашиг, алдагдал	мян,төг	0.0	-515,806.2	-515,806.2
4	Татвар - ААНБОА	мян,төг	0.0	0.0	0.0
5	Татварын дараах ашиг, алдагдал	мян,төг	0.0	-41,507.6	-41,507.6
6.1	Орлого	мян,төг	1,411,491.0	487,209.5	-924,281.5
6.2	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	мян,төг	917,491.0	487,209.5	-430,281.5
6.3	Бусад орлого	мян,төг	494,000.0	-	-494,000.0
6.4	Зардал	мян,төг	1,411,491.0	1,003,015.7	-408,475.3
6.5	Ашиг алдагдал	мян,төг	0.0	-515,806.2	-515,806.2
10	Нийт ажиллагсад	тоо	40.0	24.0	-16.0
10.1	Цалингийн сан	мян,төг	1,191,120.0	395,684.6	-795,435.4

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 843,427.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 703,062.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн орлогыг 102,944.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 77,059.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг хуримтлагдсан үр дүн дансанд 471,378.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Аймгийн ЗДТГ-т өвс нийлүүлэх гэрээтэй холбоотой 51,680.0 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй;

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 140,365.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын 5,481.1 мянган төгрөгийн түвшнээс “их” байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 140,365.7 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрснээс, 4,799.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 135,566.7 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

3.1.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах нийт 182 мэдээллээс 4 мэдээллийн хугацаа болоогүй 178 мэдээллийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.2-д “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.1.3-д “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн мэдээлэх албан шаардлага хүргүүлэв.

3.1.2 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 4,799.0 мянган төгрөгийн хөрөнгө нь байгууллагын эзэмшилд байхгүй байхад буруутай албан тушаалтнаас буцаан аваагүй, авлагаар бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “хөрөнгө, төлбөр

¹ Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.3-д “эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Буруутай албан тушаалтнаас хөрөнгийг буцаан авч байгууллагыг хохиролгүй болгох.

3.1.3 Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 2 трактор нь тус байгууллагад байхгүй бөгөөд түрээсийн гэрээгээр иргэн, аж ахуйн нэгжид шилжүүлсэн ч түрээсийн төлбөрийг аваагүй, авлагаар бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох байгууллагатай тооцоо нийлж түрээсийн гэрээнд тусгагдсан хөрөнгийн түрээсийн төлбөрийг төлүүлэн авч өр төлбөрийг барагдуулан ажиллах

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 93,700.7 мянган төгрөгийн орлогыг хувь хүн иргэнээс бүрдүүлсэн ч и баримт олгоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийг хэрэгжүүлэн и баримтаар орлогыг тухай бүр баталгаажуулан ажиллах

3.2.2 Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 41,866.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан ч бараа материалын орлогыг бүртгэхдээ НӨАТ-ыг салгаж бүртгээгүй байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйл “Албан татварт хасалт хийх”, 14.1.1-д “Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан барааны НӨАТ-ийг хасалт хийж цэвэр дүнгээр нь бүртгэх

3.2.3 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1000 тн зоорь болон үйлдвэрүүдийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй, орлого олох нөөц боломжийг бүрэн ашиглаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-д “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, 26 дугаар зүйл “Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана” гэсэн

заалтуудтай нийцээгүй санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ашиглалтыг сайжруулж орлого бүрдүүлэх нөөц боломжийг бүрэн ашиглан ажиллах

3.2.4 НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Тайлант онд ховд агро парк ХХК-ийн санхүүгийн тайланг Шинэ ховд ББХК ОНӨОХХК-ийн санхүүгийн тайланд нэгтгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д “Нэг буюу түүнээс дээш охин компанитай аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 3.1.11-д заасан нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргана. Охин компани нь охин компанитай, тэдгээр нь охин компанитай гэх мэтээр үргэлжилсэн холбоо хамааралтай байгаа тохиолдолд хамгийн дээд шатны толгой компани нь нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргана. Дээд шатны толгой компани нь гадаад улсад бүртгэлтэй бол Монгол Улсад бүртгэлтэй охин компаниудын дотроос дээд шатны толгой компани нь завсрын нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргана”, гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ховд агро парк ХХК-ийн санхүүгийн тайланг нэгтгэн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Шинэ ховд ББХК ОНӨОХХК	Орлогыг илүү илэрхийлсэн	1	102,944.2			1	102,944.2	1	102,944.2				
	Хуримтлагдсан элэгдлийг дутуу тайлагнасан	1	77,059.7			1	77,059.7	1	77,059.7				
	Хуримтлагдсан үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн	1	471,378.2			1	471,378.2	1	471,378.2				
	Өр төлбөрийг бүртгээгүй	1	51,680.0	1	51,680.0			1	51,680.0				
ДҮН		4	703,062.2	1	51,680.0	3	651,382.2	4	703,062.2				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Шинэ ховд ББХК ОНӨОХХК	Борлуулалтын и баримт олгоогүй	1	93,700.7					1	93,700.7			
	Бараа материалын НӨАТ-ийг хасаагүй нийт дүнгээр бүртгэсэн	1	41,866.0					1	41,866.0			
	Дутагдсан хөрөнгийг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй	1	4,799.0			1	4,799.0					
	Хөрөнгийн ашиглалтыг сайжруулж олох олох нөөц боломжийг алдсан	1							1	0		
	Салбар байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгээгүй байна.	1							1	-		
	Хөрөнгө түрээсэлсний авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй	1	-				1			-		
ДҮН		6	140,365.7			2	4,799.0	4	135,566.7			

4.3 Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Шинэ ховд ББХК ОНӨОХХК	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй	1	-			1	0		0
Нийт дүн		1	0	0	0	1	0		0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		